

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын эрүүл мэндийн төвийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын хураангуй тайлан**

Аудитын код: ХӨА-2026/005/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум

2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Б.Ариунтуяа

Утас: 99036832 Цахим хаяг: [ariuntuyab@audit.gov.mn](mailto:ariuntuyab@audit.gov.mn)

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaaa@yahoo.com](mailto:b_myadagmaaa@yahoo.com)

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: [Munkhtuya2220@gmail.com](mailto:Munkhtuya2220@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793. Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.09.25 № 01/183  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААННУУР  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Д.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА

#### Хараат бус аудиторын дүгнэлт

##### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

##### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Цагааннуур сумын Эрүүл мэндийн төв нь 2025 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 31,782.3 мянган төгрөгийн санхүүжилтийн авлагатай гарсан байна.

##### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 12,813.8 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илрүүлж, 340.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 12,473.8 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өглөө.

##### Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2025 оны гэрээний биелэлтийг 93.0 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>151,859,649.33</u></b>	<b><u>208,696,323.13</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	111,163.12	38,844,084.50
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	111,163.12	38,844,084.50
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	111,163.12	38,844,084.50
31211	Төрийн сангийн харилцах	111,163.12	38,844,084.50
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	31,320,942.37	32,412,240.77
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	505,305.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	27,837,038.23	31,782,340.77
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	2,978,599.14	629,900.00
3351	Байгууллагаас авах авлага	2,978,599.14	629,900.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	120,427,543.84	137,439,997.86
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	37,750,208.89	41,481,194.41
35130	Эм боох материал	37,750,208.89	41,481,194.41
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	82,677,334.95	95,958,803.45
35410	Бичиг хэргийн материал	1,405,450.00	1,603,080.00
35420	Аж ахуйн материал	18,267,959.33	20,778,359.33
35430	Сэлбэг хэрэгсэл	5,856,000.00	11,947,400.00
35440	Түлш, шатах тослох материал	14,825,839.60	12,084,719.60
35450	Барилгын засварын материал	9,556,100.00	12,523,100.00
35460	Хүнсний материал	3,416,358.90	3,602,517.40
35470	Бусад хангамжийн материал	29,349,627.12	33,419,627.12
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>354,927,963.97</u></b>	<b><u>351,625,254.32</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	354,927,963.97	351,625,254.32
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	335,913,963.77	332,691,254.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	296,226,943.82	296,226,943.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	-90,660,552.98	-103,320,024.26
39203	Авто-тээврийн хэрэгсэл	103,112,533.00	103,112,533.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-86,863,361.03	-102,457,116.62
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	291,801,793.50	354,403,793.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-183,004,568.34	-221,504,926.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,152,200.00	17,352,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,851,024.20	-11,122,149.04
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,529,000.00	1,529,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,529,000.00	-1,529,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	19,014,000.20	18,934,000.28
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-199,999.80	-279,999.72
39303	Бусад биет бус хөрөнгө	18,814,000.00	18,814,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>506,787,613.30</u></b>	<b><u>560,321,577.45</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>7,967,463.87</u></b>	<b><u>4,412,987.92</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	7,967,463.87	4,412,987.92
<b>413</b>	<b>Өглөг</b>	7,967,463.87	4,412,987.92
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,490,345.39	2,584,888.96
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,282,475.64	1,600,348.96
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	194,642.84	227,750.00
41361	Байгууллагад төлөх өглөг	194,642.84	147,750.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	80,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>498,820,149.43</u></b>	<b><u>555,908,589.53</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	498,820,149.43	555,908,589.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	265,519,675.00	265,519,675.00

51101	Өмч: - төрийн	265,519,675.00	265,519,675.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	169,361,876.93	226,450,317.03
51210	Өмнөх үеийн үр дүн	169,361,876.93	169,361,876.93
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	57,088,440.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	63,938,597.50	63,938,597.50
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>506,787,613.30</b>	<b>560,321,577.45</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>951,397,809.44</b>	<b>1,157,706,391.64</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>85,042,525.41</b>	<b>114,971,700.94</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	85,042,525.41	114,971,700.94
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	85,042,525.41	114,971,700.94
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,486,000.00	43,779,735.50
1200017	Үнэ төлбөргүй орлого-үндсэн хөрөнгө	43,403,060.00	56,802,000.00
1200018	Үнэ төлбөргүй орлого-бараа материал	20,153,465.41	14,389,965.44
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>866,355,284.03</b>	<b>1,042,734,690.70</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	45,520,000.00	58,182,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,520,000.00	58,182,800.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	820,835,284.03	984,551,890.70
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	820,835,284.03	984,551,890.70
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>927,011,814.55</b>	<b>1,100,617,951.54</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>927,011,814.55</b>	<b>1,100,617,951.54</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	905,508,175.32	1,050,285,042.62
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	600,355,738.53	711,359,356.58
210101	Үндсэн цалин	321,172,009.03	419,995,031.38
210102	Нэмэгдэл	217,395,616.02	220,600,875.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,501,113.48	23,891,000.00
210104	Урамшуулал	42,287,000.00	46,872,450.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	64,208,258.91	80,977,498.45
210201	Тэтгэврийн даатгал	42,022,058.91	52,928,559.19
210202	Тэтгэмжийн даатгал	5,450,700.00	7,147,272.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,789,200.00	3,840,703.14
210204	Ажилгүйдлийн даатгал	2,789,200.00	2,764,389.64
210205	Эрүүл мэндийн даатгал	11,157,100.00	14,296,573.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	33,512,903.61	36,258,183.24
210301	Гэрэл, цахилгаан	4,282,503.61	7,377,063.24
210302	Түлш, халаалт	28,130,400.00	28,501,120.00
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	380,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	36,758,663.50	51,185,567.98
210401	Бичиг хэрэг	3,262,080.00	4,013,470.00
210402	Тээвэр, шатахуун	29,245,063.00	39,698,235.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,925,000.00	2,574,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,175,550.00	2,804,250.00
210408	Бараа материал акталсны зардал	150,970.50	2,095,312.98
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	62,011,937.24	65,761,668.76
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48,360,066.74	46,637,009.26
210502	Хоол, хүнс	13,651,870.50	19,124,659.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,068,830.00	13,331,120.00
210604	Урсгал засвар	18,068,830.00	13,331,120.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,050,800.00	4,850,000.00

210702	Дотоод албан томилолт	5,050,800.00	4,850,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,152,494.00</b>	<b>18,216,937.96</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72,000.00	16,066,787.96
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,500.00	324,023.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	44,010.00
210807	Газрын төлбөр	41,520.00	186,117.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	832,474.00	444,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>83,388,549.53</b>	<b>68,344,709.65</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,183,950.00	240,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	80,204,599.53	68,104,709.65
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21,503,639.23</b>	<b>50,332,908.92</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,246,000.00</b>	<b>42,399,515.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	33,915,515.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,246,000.00	8,484,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>257,639.23</b>	<b>7,933,393.92</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	257,639.23	7,933,393.92
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>24,385,994.89</b>	<b>57,088,440.10</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>24,385,994.89</b>	<b>57,088,440.10</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>849,220,153.10</b>	<b>1,082,569,123.66</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>21,486,000.00</b>	<b>43,779,735.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	21,486,000.00	43,779,735.50
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	21,486,000.00	43,779,735.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,486,000.00	43,779,735.50
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>827,734,153.10</b>	<b>1,038,789,388.16</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>45,520,000.00</b>	<b>58,182,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,520,000.00	58,182,800.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>782,214,153.10</b>	<b>980,606,588.16</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	782,214,153.10	980,606,588.16
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>856,575,087.84</b>	<b>1,035,836,202.28</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>856,575,087.84</b>	<b>1,035,836,202.28</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>835,071,448.61</b>	<b>985,503,293.36</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>599,906,698.14</b>	<b>701,692,322.76</b>
210101	Үндсэн цалин	320,722,968.64	328,018,198.29
210102	Нэмэгдэл	217,395,616.02	258,135,307.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,501,113.48	26,780,920.00
210104	Урамшуулал	42,287,000.00	88,757,897.42
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>69,603,700.00</b>	<b>88,695,984.56</b>
210201	Тэтгэврийн даатгал	47,417,500.00	62,204,783.56
210202	Тэтгэмжийн даатгал	5,450,700.00	7,333,800.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,789,200.00	3,738,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,789,200.00	3,738,801.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,157,100.00	11,679,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,262,360.77</b>	<b>35,664,063.24</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,742,360.77	7,377,063.24
210302	Түлш, халаалт	34,420,000.00	25,760,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	2,527,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>36,253,440.00</b>	<b>45,974,935.00</b>
210401	Бичиг хэрэг	4,054,380.00	2,769,400.00
210402	Тээвэр, шатахуун	29,274,060.00	37,551,235.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,925,000.00	2,574,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	1,080,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	2,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>51,692,425.70</b>	<b>57,752,357.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,724,280.70	40,661,857.00
210502	Хоол, хүнс	18,468,145.00	15,215,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,875,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>26,640,580.00</b>	<b>25,537,142.84</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,891,000.00	2,442,500.00
210604	Урсгал засвар	23,749,580.00	23,094,642.84
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,050,800.00</b>	<b>4,930,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,050,800.00	4,850,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,152,494.00</b>	<b>18,216,937.96</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72,000.00	16,066,787.96
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,500.00	199,684.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	143,484.00
210807	Газрын төлбөр	41,520.00	210,982.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	832,474.00	444,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,508,950.00</b>	<b>7,119,550.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,508,950.00	7,119,550.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21,503,639.23</b>	<b>50,332,908.92</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,246,000.00</b>	<b>42,399,515.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	33,915,515.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,246,000.00	8,484,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>257,639.23</b>	<b>7,933,393.92</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	257,639.23	7,933,393.92
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b><u>957,000.00</u></b>	<b><u>8,000,000.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>957,000.00</u></b>	<b><u>8,000,000.00</u></b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>957,000.00</b>	<b>8,000,000.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-957,000.00</u></b>	<b><u>-8,000,000.00</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-8,311,934.74</b>	<b>38,732,921.38</b>

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,423,097.86	111,163.12
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	111,163.12	38,844,084.50

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	265,519,675.00	63,938,597.50	254,859,252.54	584,317,525.04
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-109,883,370.50	-109,883,370.50
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>265,519,675.00</b>	<b>63,938,597.50</b>	<b>169,361,876.93</b>	<b>498,820,149.43</b>
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	57,088,440.10	57,088,440.10
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>265,519,675.00</b>	<b>63,938,597.50</b>	<b>226,450,317.03</b>	<b>555,908,589.53</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### Улсын төсвийн гүйцэтгэл:

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,061,566,700.00</b>	<b>1,024,386,323.66</b>	<b>37,180,376.34</b>	<b>96.50</b>
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>1,061,566,700.00</b>	<b>1,024,386,323.66</b>	<b>37,180,376.34</b>	<b>96.50</b>
120	Нийтлэг татварын бус орлого	63,111,800.00	43,779,735.50	19,332,064.50	69.37
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	63,111,800.00	43,779,735.50	19,332,064.50	69.37
122	Тусламжийн орлого	998,454,900.00	980,606,588.16	17,848,311.84	98.21
122001	Хандив тусламж /дотоод/	998,454,900.00	980,606,588.16	17,848,311.84	98.21
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,061,677,900.00</b>	<b>985,653,402.28</b>	<b>76,024,497.72</b>	<b>92.84</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,061,677,900.00</b>	<b>985,653,402.28</b>	<b>76,024,497.72</b>	<b>92.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,015,496,300.00</b>	<b>943,253,887.28</b>	<b>72,242,412.72</b>	<b>92.89</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>747,184,600.00</b>	<b>701,692,322.76</b>	<b>45,492,277.24</b>	<b>93.91</b>
210101	Үндсэн цалин	221,305,000.00	328,018,198.29	-	148.22
210102	Нэмэгдэл	404,043,900.00	258,135,307.05	145,908,592.95	63.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,577,300.00	26,780,920.00	31,796,380.00	45.72
210104	Урамшуулал	63,258,400.00	88,757,897.42	-25,499,497.42	140.31
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>99,316,800.00</b>	<b>88,695,984.56</b>	<b>10,620,815.44</b>	<b>89.31</b>
210201	Тэтгэврийн даатгал	66,897,800.00	62,204,783.56	4,693,016.44	92.98
210202	Тэтгэмжийн даатгал	8,104,800.00	7,333,800.00	771,000.00	90.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,052,300.00	3,738,800.00	313,500.00	92.26
210204	Ажилгүйдлийн даатгал	4,052,300.00	3,738,801.00	313,499.00	92.26
210205	Эрүүл мэндийн даатгал	16,209,600.00	11,679,800.00	4,529,800.00	72.05
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>50,324,800.00</b>	<b>45,974,935.00</b>	<b>4,349,865.00</b>	<b>91.36</b>
210401	Бичиг хэрэг	4,308,700.00	2,769,400.00	1,539,300.00	64.27
210402	Тээвэр, шатахуун	38,000,000.00	37,551,235.00	448,765.00	98.82
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,016,100.00	2,574,300.00	441,800.00	85.35

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	1,080,000.00	1,920,000.00	36.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	2,000,000.00	00.00	100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>65,313,800.00</b>	<b>57,752,357.00</b>	<b>7,561,443.00</b>	<b>88.42</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44,176,700.00	40,661,857.00	3,514,843.00	92.04
210502	Хоол, хүнс	19,637,100.00	15,215,500.00	4,421,600.00	77.48
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,875,000.00	-375,000.00	125.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>18,951,800.00</b>	<b>18,951,800.00</b>	<b>00.00</b>	<b>100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	5,975,800.00	-1,975,800.00	149.40
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	111,200.00	00.00	111,200.00	00.00
210604	Урсгал засвар	14,840,600.00	12,976,000.00	1,864,600.00	87.44
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,149,700.00</b>	<b>4,850,000.00</b>	<b>299,700.00</b>	<b>94.18</b>
210702	Дотоод албан томилолт	5,149,700.00	4,850,000.00	299,700.00	94.18
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>19,429,800.00</b>	<b>18,216,937.96</b>	<b>1,212,862.04</b>	<b>93.76</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,882,900.00	16,066,787.96	-183,887.96	101.16
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,152,000.00	348,000.00	76.80
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	00.00	100,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	199,684.00	316.00	99.84
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	143,484.00	6,516.00	95.66
210807	Газрын төлбөр	500,000.00	210,982.00	289,018.00	42.20
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,096,900.00	444,000.00	652,900.00	40.48
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9825000.00</b>	<b>7119550.00</b>	<b>2705450.00</b>	<b>72.46</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,825,000.00	7,119,550.00	2,705,450.00	72.46
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>46,181,600.00</b>	<b>42,399,515.00</b>	<b>3,782,085.00</b>	<b>91.81</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>46,181,600.00</b>	<b>42,399,515.00</b>	<b>3,782,085.00</b>	<b>91.81</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,697,600.00	33,915,515.00	3,782,085.00	89.97
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,484,000.00	8,484,000.00	00.00	100.00
<b>8</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИИТ ТЭНЦЭЛ</b>	<b>-111,200.00</b>	<b>38,732,921.38</b>		
<b>9</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>111,200.00</b>	<b>-38,732,921.38</b>		
<b>7</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>111,200.00</b>	<b>-38,732,921.38</b>		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	111,200.00	111,163.12		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	38,844,084.50		

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>58,182,800.00</b>	<b>50,249,406.08</b>	<b>7,933,393.92</b>	<b>86.36</b>
12	Татварын бус орлого	58,182,800.00	50,249,406.08	7,933,393.92	86.36
122	Тусламжийн орлого	58,182,800.00	50,249,406.08	7,933,393.92	86.36
122005	Төсвөөс санхүүжих	58,182,800.00	50,249,406.08	7,933,393.92	86.36
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>58,182,800.00</b>	<b>50,249,406.08</b>	<b>7,933,393.92</b>	<b>86.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>58,182,800.00</b>	<b>50,249,406.08</b>	<b>7,933,393.92</b>	<b>86.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>58,182,800.00</b>	<b>50,249,406.08</b>	<b>7,933,393.92</b>	<b>86.36</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,000,000.00</b>	<b>35,664,063.24</b>	<b>4,335,936.76</b>	<b>89.16</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,000,000.00	7,377,063.24	7,622,936.76	49.18
210302	Түлш, халаалт	20,000,000.00	25,760,000.00	(5,760,000.00)	128.80
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	2,527,000.00	2,473,000.00	50.54
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,182,800.00	14,585,342.84	3,597,457.16	80.22
210604	Урсгал засвар	18,182,800.00	14,585,342.84	3,597,457.16	80.22
8	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	-	-		
9	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	-		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-		

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 12,813.8 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрснээс, 340.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 12,473.8 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгч, нийцлийн асуудалтай холбоотой 2 зөрчилд албан шаардлага, 1 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлжээ.

**3.1 Залруулсан алдаа**

- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан маягтаар төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэж ирүүлээгүй байсныг нөхөж гаргасан.
- Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 80.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1 "үнэн зөв байх" заалттай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул залруулга бичилт хийсэн.
- Ажиллагсад хоолны мөнгө, томилот 260.0 мянган төгрөг давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" заалттай нийцэхгүй, "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад байгууллагын дансанд тушааж, хохиролгүй болгосон.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 12,473.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 14,832.2 мянган төгрөгөөс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

### 3.2 Албан шаардлага

- Цагааннуур сумын эрүүл мэндийн төв нь тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй, дээд шатны төсөв захирагчаар батлуулаагүй, тайлагнаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 заалтад “Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ.” гэж заасантай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байх тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.
- Тус эрүүл мэндийн төв нь 2025 онд цахим дэлгүүрээс эмийн худалдан авалтыг хийгээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 заалтад заасан “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна.” заалт, Засгийн газрын 2024 оны 162 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байх тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.
- Цагааннуур сумын эрүүл мэндийн төв нь шилэн дансны цахим хуудсанд мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байх тул шилэн дансны мэдээлэл хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Авто машинд зарцуулсан 8,917.4 мянган төгрөгийн сэлбэгийг зарлагадаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6 “бүх зардал;” гэж заасантай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Ашиглалтын норм, хугацаатай сэлбэг хэрэгслээс бусад сэлбэгийг тухай бүрд нь зарцуулж байх

#### 2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт 1:

Өмнөх онуудын болон байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасагдсан боловч улсын бүртгэлээс хасагдаагүй 343.2 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн татвар, төлбөр, хураамжийг нөхөн төлсөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Байгууллагын нягтлан бодох бүртгэлээс хасагдсан боловч улсын бүртгэлээс хасагдаагүй тээврийн хэрэгслийг хасуулах

Илрүүлэлт 2 :

Төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж 3,213.2 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Батлагдсан маягтаар тайланг бэлтгэж ирүүлээгүй	1	-	1	-			1	-		
Орлогыг зөрүүтэй тайлагнасан	1	80.0			1	80.0	1	80.0		
Томилолтоор ажилласан үед хоолны мөнгө давхардуулж олгосон	1	260.0			1	260.0	1	260.0		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>340.0</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>340.0</b>	<b>3</b>	<b>340.0</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авто машинд зарцуулсан сэлбэгийг зарлагадаагүй	1	8,917.4					1	8,917.4
Данснаас хасагдсан тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулаагүй, татварыг нь нөхөж төлсөн.	1	343.2					1	343.2
Эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн	1	3,213.2					1	3,213.2
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>12,473.8</b>					<b>3</b>	<b>12,473.8</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим системд оруулж, батлуулаагүй, тайлагнаагүй	1	-			1	-		
Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	-			1	-		
Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь өмнөх оны албан шаардлыг хэрэгжүүлээгүй	1	-			1	-		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>-</b>			<b>3</b>	<b>-</b>		

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			